



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/213

Чингис хот

Байнгын байршил тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтууд, Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дархан сумын нутаг дэвсгэрт байрлах Цагаан толгой нэртэй MV-021443 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий "ХТД" ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын газрын байнгын байршлыг хавсралтад заасан солбицлуудаар тогтоосугай.

2. Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг "ХТД" ХХК-д зөвлөсүгэй.

3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг газрын мэдээллийн санд бүртгэж, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт хяналт тавьж, иргэд аж ахуйн нэгжид газар олгохгүй байхыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Д.Баярхүү), Дархан сумын Засаг дарга (Ж.Энхтөр) нарт, тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах, тээвэрлэх, ашиглах аюулгүйн ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Б.Сүнгээ), Цагдаагийн газрын дарга (Б.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011309

05 Аймгийн Засаг даргын 2021 оны  
дугаар сарын 04 өдрийн А/213  
дугаар захирамжийн хавсралт



“ХТД” ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн  
агуулахын газрын байнгын байршил

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	46	19	21.07	109	23	24.15
2	46	19	21.14	109	23	28.61
3	46	19	18.17	109	23	25.7
4	46	19	18.22	109	12	24.24